



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/340

Мандалговь

Тусгай зөвшөөрлийн эрх сунгах,
түдгэлзүүлэх, хүчингүй
болгох тухай

Монгол Улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дүгээр зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хулд сумын "Хулд манлай", Гурвансайхан сумын "Буман цагаан хонь", Эрдэнэдалай сумын "Аравжих аз хур", Өндөршил сумын "Мөнхдүүрэн арвай", Сайнцагаан сумын "Ихэр гэр чулуут", "Хишиг өгөөмөр", "Эгшиглэнт бүрд" ХХК-ний хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2018 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 7 дугаар сарын 25-ны өдөр хүртэл хугацаагаар тус тус олгосугай.

Хоёр. Сайхан-Овоо сумын "Онгийн хийд", "Сайханговь", "Онгийн нууц", "Цогтын шар мөрөн", Сайнцагаан сумын "Эрдэнэ-Ухаа", ОНӨНҮҮГазрын "Сүм хөх бүрд" жуулчны баазуудын согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2018 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 1-ны өдрийг хүртэл хугацаагаар олгосугай.

Гурав. Сайнцагаан сумын "Зотол мандал" ХХК-ний жуулчны баазын тусгай зөвшөөрлийн эрхийг түр түдгэлзүүлсүгэй.

Дөрөв. Сайнцагаан сумын "Ээлт мөнх наран", Дэлгэрхангай сумын "Дөлгөөн хан" ХХК-иудын тусгай зөвшөөрлийн эрхийг 2018 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс хүчингүй болгосугай.

Тав. Тусгай зөвшөөрлийн эрх сунгагдсан "Хулд манлай", Гурвансайхан сумын "Буман цагаан хонь", Эрдэнэдалай сумын "Аравжих аз хур", Сайнцагаан сумын "Ихэр гэр чулуут", "Эгшиглэнт бүрд" ХХК-ний худалдааны газрын ажиллах

488010112

цагийн хуваарийн 09.00 -24.00 цаг хүртэл "Хишиг өгөөмөр", Сайхан-Овоо сумын "Онгийн хийд", "Сайханговь", "Онгийн нууц", "Цогтын шар мөрөн", Сайнцагаан сумын "Эрдэнэ-Ухаа", ОНӨНҮҮГазрын "Сүм хөх бүрд" жуулчны баазуудын ажиллах цагийн хязгаарыг 09.00 -24.00 цаг хүртэл хугацаагаар баталсугай.

Зургаа. Тусгай зөвшөөрлийн эрхийг олгосон шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Ц.Сугаржав), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж.МӨНХЧУЛУУН